

# 1. Хог хаягдлыг ялган цуглуулах, мөнгөн бус хэлбэрээр урамшуулах төсөл

## ЗОРИЛГО

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байршуулсан ухаалаг хогийн саванд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа ангилан цуглуулах бүрд мөнгөн бус хэлбэрээр урамшуулал өгч, дадал зуршил суулгах.

**12.25**  
тэрбум  
төгрөг

## ХҮРЭХ ҮР, ДҮН

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа төрөлжүүлэн хаях дадал зуршилтай болж, байгаль орчинд хог хаягдлаас үүдэх хор хөнөөл багасаж, илүү бага хог хаягдлыг хогийн цэг болон ландфилд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нэмэгдэнэ.

## ХАМРАХ ХҮРЭЭ, ҮНДЭСЛЭЛ

- ✓ Хог хаягдлын тухай хуулийн 411 дүгээр зүйлийн 411.1 дэх хэсэгт “Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, төрөлжүүлэн ангилах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлж болно.”
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2020 оны ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 4.6.7-д “Иргэдийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн хөгжлийг дэмжих төслүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.”, 9.2.27-д “Бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг нэмэгдүүлэхэд захиргааны болон урамшууллын аргыг хослуулан хэрэглэнэ.”, 9.2.29-т “Хог хаягдлыг ангилан ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, стандартыг бий болгох, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг цэвэрлэж, нөхөн сэргээнэ.”
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын хавсралтын 6.1.90-д “Хог хаягдлын менежментийг сайжруулж, гэр хорооллын айл өрхийг үнс хадгалах зориулалтын савтай болгож, дахин боловсруулах бүх төрлийн үйлдвэрийг байгуулна.”